



Ажлын байр



Гадна тал



Дотор тал



Хүлэмж



Малын байр



Шуууны байр

Түүхий эд, материалын орц

№	Түүхий эд материал /4м х5м хэмжээтэй байгууламж/	Х. нэгж	Тоо хэмжээ
1	Элсний хут	ш	1800
2	Цемент	тн	4
3	Элс	тн	30
4	Хайрца	тн	30
5	Газарийн бичиг /5смх270смх15см/	ш	30
6	Батана хинх орус мод	ш	9
7	Төмөр сеткэн тор	ш	22
8	Хөвдөнцөр /5 см. зөөлөн/	м ²	45
9	Газарийн төмөр	ш	12
10	Цанерь газарц	ш	1
11	Цонх	ш	1
12	Хаялга	ш	1
13	Мандсан утас/төмөр утас	м	150
14	С.коч	ш	8
15	Халдас	кг	18

Зуны сууц



Empowered lives.
Resilient nations.

Алт олборлолтод мөнгөн усыг хэрэглэнээс гаргах тосолд хамрагдагсад зориулав

Ууталсан шороогоор жигжиг барилга, байгууламж барих гарын авлага

Манай хаяг: Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн
Жэжис Төслийн Хотолбор, НУБ-ын Хөгжлийн Хотөлбор,
НУБ-ын байр, НУБ-ын гудамж-14, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14201, Монгол улс.

Утас: 976 (11) 327585 ext-1140, 70112883

Цахим шуудан: ganbaatar.bandi@undp.org

narangaarav.gunkhuuyag@undp.org

Энэхүү гарын аелагыг зөвхөн нэг давхар, ахуйн хэрэглээний жижиг барилга, байгууламжийг барихад ашиглана. Ийм барилга байгууламжуудад малын хашаа, сараач, гахай, шугууны байр, автомашинны гараж, зoorь, склад, хүлэмжний хана гэх мэт жижиг байгууламжууд орно. Мөн офисын жижиг байр, хүн амьдрах оромж барьж болохыг түршиж үзсэн байна. Түүнчлэн манай орны говь хээрийн бүсэд энэ аргаар малын хашаа, сараач барихад салхи нэвтрүүлэхгүй, дулаан, нэн тохиромжтой байх талтай. Хэрэв гадна талын шаваас хуурч нар, салхи үзэж шороотой уут гэмтэхгүй бол 60-70 жил эвдэрч нурах асуудал үүсэхгүй.



Барилгын ажлын бэлтгэл

Ууталсан элс шороогоор жижиг барилга байгууламж барихад үндсэн түүхий эд болох элс, эсвэл хуурай шороо, цемент, уут 25 кг гурилын), төмөр тор, нарийн төмөр утас эсвэл мяндсан утас, дээврийн төмөр, банк болон брус мод, ус зэргийг бэлтгэнэ. Ажлын багаж хэрэгсэл болох алх, бахь, скоч, нээвий, метр, жин, хүрз, хувин, шигшүүр, шат, маркер үзэг, бээлий, бетон зуурах хэрэгсэлүүд шаардлагатай.

Барилгын ажил



Ажлын эхэнд элстэй нэг уутны урт, өргөний хэмжээг ямар байхыг тогтоож түүндээ үндэслэн барих байгууламжийнхаа урт, өргөнд хэдэн ширхэг элстэй уут орохыг тооцоолон гаргавал цаашдын ажил, тооцоонд алдаа гарах эрсдэлээс зайлсхийж болно. Үүний тулд нэг уут авч түүндээ элсээ (эсвэл шороогоо) хийж орцын хэмжээг тааруулсны дараа хувинд юүлэн тэмдэглэгээ хийж түүнийг ашиглан уутлах ажлыг хялбарчлах нь зүйтэй. Элсний оронд өнгөн хөрсний доод давхаргын хуурай, шимгүй шороог ууталахад элснээс бараг дутахгүй бөгөөд эдийн засаг, экологийн хувьд ач холбогдолтой байж болно.

Орцын хэмжээг тааруулахдаа элстэй уутаа хажуугаар нь хэвтүүлэн дарж хавтгайлахад ойролцоогоор уутны гуравны хоёр нь элсээр дүүрч гуравны нэгийг нь эргүүлэн нугалж скочоор даруулж болохоор тохируулан бэлтгээд урт, өргөний хэмжээг авч цонх, хаалга, дээврийн гээд цаашдын бүхий л тооцоондоо ашиглаж болно. Цонх, хаалгыг өөрийн хүссэн хэмжээгээр банзаар зангидаж хана өрөлгийн явцад тооцооны дагуу суулгаж бэхэлнэ. Үүний дараа барилгын суурийн хэмжээг тооцож гарган газарт тэмдэглэж цементээр цутгах ажлаа эхэлнэ. Суурийн өргөнийг уутны өргөнтэй адил байхаар тооцохын зэрэгцээ зузааныг тухайн орчны газрын хөрсний нягтаршил, ханын өндөр, борооны усанд автах



эрсдэлийг харгалзан бодож гаргах бөгөөд давхар бус дан байгууламж тул ерөнхийдөө 10-15 см байхад хангалттай гэж үзэж болно. Их хатуу хөрстэй, бороо, усанд автах ямарч эрсдэлгүй бол суурь цутгалгүйгээр шууд газар дээр нь нарийн хайрга бага зэрэг асгаад ханаа өрж ч болох талтай.

Суурийг цутгаж хатаасны дараа ханаа өрөх ажилдаа орно. Элстэй шуудайн нугалж скочдсон талыг дээш харуулж эхний үеийг дараалуулан хооронд нь сайн шахаж өрнө. Харин дараагийн үеүүдийг доод үеийнхээ хоёр уутны нийлсэн амсрыг дарах байдлаар өрж явна. Ер нь ийм байгууламжийн ханыг 2.20 метрээс өндөргүй байхыг зөвлөдөг. Хана өрөх явцад тэгш усаар байнга хэмжилт хийж аливаа хазайлт муруйлтыг гаргахгүй байхад онцгой анхаарна. Өрлөг хийхдээ төмөр торыг ханын дотор гадна талд нь татаж бэхлэх төмөр эсвэл мяндсан утсыг 2 уут алгасаад хоёр уутны нийлсэн хэсгээр хоёр талдаа 13-15 см урттай гарсан байхаар байрлуулж явна.

Ханыг өрж дуусаад дээврийн суурь болох зузаан банзыг дээгүүр нь ханаа дагуулан тавьж төмөр тороор ханын дотор талын доод ирмэгээс гадна талын доод ирмэг хүртэл хүчинэ. Үүний дараа ханын 2 тал руу нь гаргасан нарийн төмөр эсвэл мяндсан утсуудаар торыг хананд ойртуулан татаж уях ажлыг хийж дуусгаад ханаа зуурмагаар шавна. Зуурмаг нь барьцалдах чадвар сайтай, биетэй, хурдан хатдаг байвал сайн. Барилгын ажилд дадлагажсан хүмүүс нээвий ашиглан цэвэрхэн шавчдаг бол модон хавтан ашиглан цементэн зуурмагаар цутгалт хийж болно. Нэгэнт дээврийн суурь банзыг хананд төмөр тороор даруулж шавж бэхэлсэн тул тааз, дээвэрээ өөрийн үзэмжээр буюу бусад энгийн байгууламжуудын адил хэлбэр, загвартай хийж болно. Гэхдээ хавар, намрын хүчтэй салхи шуурганд тэсвэртэй байдлыг сайтар бодолцох нь зүйтэй.